

ХҮННҮГИЙН ЯЗГУУРТАН НОЁДЫН ХЭРЭГЛЭЖ БАЙСАН  
ХОЁР ЦОЛЫН ТУХАЙ

Б.Батсүрэн

**Түлхүүр үг:** *Хүннү, цол, гули, лули, данху, хури, тамма*

Хүннүгийн төр, нийгмийн байгууллын бүтэц өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Хүннүгийн төр «дээрээс доош» гэсэн зарчмаар байгуулагдах ба энэхүү төрийн засаг захиргааны тогтолцоо нь төрийн шийдвэрийг засаг захиргааны доод нэгж болон албат иргэдэд шуурхай, шууд хүргэн хэрэгжүүлэх зарчимд тулгуурласан хялбар боловч үр өгөөжтэй тогтолцоо хэмээн судлаачид үзжээ (Дэлгэржаргал нар, 2017:163).

Хүннүгийн нийгмийн байгууллын судалгаанд төрийн албыг хашигч, угсаа язгууртай ноёдынх нь хэрэглэж байсан цол хэргэм, зэрэг дэвийн шинжлэл тодорхой хувь нэмэртэй.

Энэхүү өгүүллээр, бид бүхэн хүннүгийн язгууртны цолууд дотроос эхний хоёр ба тавдугаар<sup>1</sup> дэсэд эрэмбэлэгддэг *гули* ба *данху* гэсэн хоёр цолын талаарх өөрсдийн саналыг толилуулж байна.

**Гули** ван. Хүннүгийн төрийн түшмэдийн хоёр дахь дэсийн том албан тушаалтан, харин *шаньюй* (\*дарга) хийгээд *зүүн, баруун дуги* (туци буюу \*дигин) нарыг оруулж тооцвол Хүннүгийн төрийн дээрээсээ дөрөв, тавд эрэмбэлэгддэг язгууртны цолыг эрдэмтэд “гули” (Я.Я.М. де Гро, О.Прицак, Г.Сүхбаатар, Н.Ямада) эсвэл “лули” (Н.Я.Бичурин, А.Вайли, Э.Паркер, Б.Уатсон, М.Мори, В.С.Таскин, Э.Гил) гэж хоёр янзаар уншжээ.

*Лули* биш *гули* гэдэг дуудлагыг баримтлах болсон учраа де Гро *гули* гэж ямар утгатай үг болохыг бичвэрт тэмдэглэж үлдээсэн зүйлгүй, «*Ši ki tsi' kiai*»<sup>2</sup> болон Янь Шигу хийгээд «Кансигийн толь»-д дурдсанаар бол тодорхой тохиолдолд *гу* (kok)-г *лу* (lok) гэж дуудаж болдгийг тэмдэглээд, гэхдээ *хятадууд* уламжлахдаа гажуудуулах нь мэдээж, бас *лули* угаасаа *гули* учир орчуулганд *гули* (kok-le)-г сонгосон гэх утгатай тайлбар хийжээ (1921:55).

*Гули* цолыг хятад сурвалжид анх МЭӨ 160-126 оны үед үзэгдсэн гэсэн О.Прицак *гули* (GS, 1202 а, 1241 о: \*kuk-liei) бол хүннү үг юм, түүний өөр нэг хятад галиг бол *лули* (GS, 1209 а, 1241 о: \*luk-liei) ба сурвалжид ямар утгатай үг болохыг заасан зүйлгүй гэж 1954 онд бичжээ<sup>3</sup>.

Яагаад *гули* гэхийн оронд *лули* гэх болсон тухай Г.Сүхбаатар “Түүхийн тэмдэглэлийг” тайлбарлагч “Фу Цянь (МЭ 125 оны орчим - 195 он) уг үгийн эхний мөр нь “гу” дуудлагатай боловч “лу” дуудлагатай гэж тайлбарласныг эрдэмтэд баримтлан “лули” гэж бичсээр ирсэн [тиймээс] “лу” заавал байх албагүй” гэсэн.

<sup>1</sup> 1. Туци (Дигин) ван; 2. Гули буюу Лули ван; 3. Их Дагян/Дацзянь ван; 4. Их Дувэй ван; 5. Их Данху ван; 6. Гудуху ван гэж эрэмбэлэгдэнэ.

<sup>2</sup> “Түүхийн тэмдэглэл”-ийн гурван гол тайлбарын нэг бөгөөд англи хэлнээ “Records of the Grand Historian, Collected Annotations” гэж орчуулсан Пэй Инь (V зуун)-ий “Шицзи цзицзе” (史記集解, shiji jijie)-г “Түүхийн тэмдэглэл, Тайлбарын эмхэтгэл” гэж болмоор.

<sup>3</sup> Pritsak O. 1981. Die 24 Ta-ch'ên. Stusie zur Geschichte des Verwaltungsaufbaus der Hsiung-nu-Reiche - Studies in Medieval Eurasian History. Variorum Reprints. London. S. 188.

Яг ижил зүйлийг БНХАУ-ын профессор Учралт хэлсэн байдаг. Тэрбээр, *гу* (谷, gu) нь *лу* (鹿, lu)-тай адил, *ли* (蠶, li) нь *ли* (離, li) болон *ли* (黎, li)-гэй адил гэсэн Фу Цяний тайлбарыг мөн дурдаад хожмын хүмүүсийн баримталсан дуудлага, тайлбар нь Фу Цяний “тайлбарыг дагаж ярьсан төдий ... одоогийн хятад хэлэнд ч Фу Чианы хэлсэнээр үндэс болгож ... *лули* (luli) гэж уншиж байна” хэмээгээд нэмж ер нь Фу Цяний хэлснийг магадлах хэрэгтэй гэж үзээд эртний хятад судар тайлбарлагч “Фу Чианы хадсан дуудлагыг буруу гэж үзнэ” (Сүхбаатар, 1980:202) хэмээжээ.

*Гули* хэмээн галиглаж үлдээсэн үгийн язгуур аль хэлэнд хамаарч болох тухай “уг үгийн нэхэн сэргээлтийг “гули” гэдгээр нь (\*kuk-liei, 1202a, 1241o) үзвэл алтайн хэлний үг байж болмоор” (1980:202) гэсэн саналыг Г.Сүхбаатар дурдаад орхисон байдаг.

*Гули* (谷蠶, guli) цол ямар хүннү үгийн галиг болохыг тайлбарласан судалгаа тун цөөн бололтой, бидний олж үзсэнээр бол Орос, Хятадын эрдэмтэд *гули*-г ямар үг болохыг тайлбарлажээ.

Түүхэнд тэмдэглэгдсэн жинхэнэ хүннү үгийг нэг бол “иран-сак үг” эсвэл “түрэг үг” гэдэг “хоёрхон цонхоор” хардаг Л.Дыбо *гули*-г ЗХ. \*kōk r(h)ə гэж уншиж болох юм, хориг, хориглосон газар, хаад ноёдын хувийн эзэмшил, нутаг, дархан цаазат газар гэсэн утгатай эртний түрэгийн “qoŋiŋ”-той холбож болно гэжээ. Түүнчлэн, *хориг*-оос гадна авиан зүйн хувьд маруухан ч утга зүйн талаас хараач, харуулын өндөр, дохионы өндөр гэх мэт утга илэрхийлдэг эртний түрэгийн «qagui» байж болно гэж үзжээ (2007:104).

“Эртний түрэг” гэдэг нэр томъёогоороо Л.Дыбо руни бичгийн дурсгал, уйгур хэлний дурсгал, Махмуд Кашгарийн толь дахь үгс болон караханид, кыпчак, цагадай хэлний хэрэглэгдэхүүнийг заасан бололтой, бүгд МЭ VIII зуунаас хойших баримтууд.

Харин судлаач Учралт, *гули*-ийн эртний дуудлагыг \*kukliei < \*kuliei < \*kuriei гэж сэргээгээд “хятад авиачилгаа [галиг нь] одоогийн монгол хэлний “хүрээ” гэсэн үг болж сэргээгдэнэ” (2015:124) хэмээн дүгнэсэн байна.

*Гули*-ийн эртний дуудлагыг сэргээхдээ Учралт профессор 1986 оны “Хятад үсгийн эртний дуудлагын гарын авлага (漢字古音手冊, hanziguyinshouce)” гэсэн Го Шилиан (郭錫良, guoxiliang)-ы судалгааг баримталжээ. Хүннү үг галигласан хоёр үсгийг Го Шилиан \*kuk-liei гэжээ, сүүлийн үсгийг бас \*lie<sup>4</sup> гэсэн тул \*kuk-lie гэх хувилбар бас байж болох юм.

Л.Дыбо, Учралт хоёрын *гули*-г “хориг”, “харгу”, “хүрээ” гэсэн эртний түрэг, эсвэл монгол хэлний үг гэсэн тайлбарууд маш эргэлзээтэй. Учралт профессорын “хүрээ” бол утга үсгийн сурвалжид “було” гэж тэмдэглэсэн, “овог” гэдэг нүүдэлчдийн нийгмийн зохион байгуулалтын цөм нэгжийг заасан “бүлэг” гэсэн монгол үгийн эквивалентаас өөр юу ч биш гэдэгтэй өнөөдөр судлаачид санал нэгдэх болсон. Тэгээд ч ноёд, язгууртны цолоор хэрэглэж байсан баримт бараг л байхгүй л болов уу. Л.Дыбогийн *гули* мөн гэсэн *хориг*, *харгу* хэмээх үг хүннү хэлэнд бий гэхдээ өөр галигаар үлдсэн гэж бид үздэг тул түүний саналыг боломжгүй гэж үзэхийн зэрэгцээ түүний санал Учралтын саналын адил нүүдэлчдийн ноёд язгууртны цол хэргэмийн уламжлал, түүхтэй баахан зөрж буйг Төв Азийн малчин нүүдэлчдийн цол хэргэмийг судалсан эрдэмтэд хэлэх байх. Хүннүгийн төрийн дээд алба хашигч, эрх баригчдын *шаньюй* (\*дарга), *дуги* (\*дигин) гэсэн цолын сэргээлтээс харвал дээрээсээ гурав дахь дэсийн, нөлөө бүхий ноёд язгууртныг - *хүрээ*, *хориг*, *харгу* гэж, аж ахуйн ч гэмээр нэр томъёогоор цоллож нэрлэх нь утга зүйн талаас хэр үнэн эсэхийг хожим нягталж шалгах буй заа. Тиймээс *гули*-г “хүрээ”, “хориг”, “харгу” гэж үзсэнийг зөв гэж дэмжих арга алга.

Ямар хүннү үгийг *гули* гэж галигласныг олохын тулд юуны өмнө *гу* (谷) *ли* (蠶) гэсэн хоёр үсгийн эрт, дундад үеийн дуудлагын сэргээлтүүдийг харьцуулах ёстой болов уу.

ОС.	*kuk-liei\lie	(Го, 1986, 92, 83)
ОСМ.	*klōk\klok-rê?	(Шюсс, 11-14, 7-22)
ОС.	*q <sup>o</sup> ok-r <sup>i</sup> ij?	(OCR, 2011, 43, 78)

<sup>4</sup> 郭錫良。漢字古音手冊。北京大學出版社，1986，т. 92, 83 (Хойшид, Го Шилиан, г.т.).

ЛН.	*kuk-le	(Шюсс, 11-14, 7-22)
МС.	kök-liellie	(Го, 1986, 92, 83)
ЕМС.	kəwk-lej'	(Пулл, 111, 187)

*Гули* гэх үгийг - МЭӨ VI-III зуун (ОС), МЭ 25-220 он (ЛН), М.Э. 600 он (МС/ЕМС) гэсэн гурван өөр цаг үеийн дуудлагыг үндэслэж хоёр хувилбар толилуулж байна.

**Нэг.** Дундад үе (МС), Хожуу Ханьгийн үеийн (ЛН) дуудлагыг баримталбал *гули* нь *хүрээ*, *хориг*, *харгу* гэхээс илүүтэй, хааны итгэмжит шадар сайд гэсэн утга агуулах монгол хэлний \*хүлэг (ЛН. \*kuk-le < \*küle(g), SHM. külük, WM. külüg) гэсэн үг байх боломжтой. Монголын эзэнт гүрний дараах үед ноёдын цолын чимэг болон хэрэглэгдэж байсан “хүлэг” нь арай эрт цагт албан тушаалтны цол байсны ул мөрийг илтгэх мэдээ “Монголын нууц товчоон”-ы 177-р зүйлд байдаг гэж үзэж болох юм. Тэнд, Хэрэйдийн Тоорил хан Найманы Хөгсүү Сабрагт довтлуулж “ард иргэдээ булаалгаж” хойно Тэмүжинд Чингис ханд элч мордуулж “хөвүүн минь дөрвөн хүлгээ өгч ирүүл” гэсэн дагуу Чингис хан “Боорчу [Боорчи], Мухули [Мухулай], Борохул, Чулуун баатар эдгээр дөрвөн «хүлгээрээ цэрэг засуулж» ...” илгээж, хүчээ өгсөн тухай өгүүлдэг (Цэрэнсодном, 2000:177).

*Хүлэг* гэж нэрлэгдсэн Чингис ханы шадрууд цэрэг захирч байгаа нь тус нэр томъёогоор нэгэн цагт тодорхой албан тушаалтныг нэрлэж байсны баримт гэж үзэж болох юм.

Нэр, алдар цуу зэрэг утга бүхий түрэг хэлний *kü* язгуурт *+lüg* дагавар залгасан түрэг үг гэж Г.Дөрфэр тайлбарлажээ. Түүний тайлбараар бол *хүлэг* (*külük*) нь түрэг хэлнээс монгол хэлэнд зээлэгдсэн гэж ойлгогдохоор<sup>5</sup>. Хэлний мэргэжилтэн биш тул *хүлэг* гэдэг үгийг монгол үг үү, эсвэл түрэг үг үү гэж яг таг хэлж чадахгүй нь ойлгомжтой. Гэвч монгол хэлний “үлэмж том, их” гэсэн утгатай *үлэг* гэсэн үгтэй гарал нэг бөгөөд нэр үг (тухайлбал, цолын нэр) болж хөгжсөн/үлдсэн учраас язгуур хэлбэрээ хадгалж үлдсэн байж болох талтай гэмээр.

**Хоёр.** О.Прицакийн тогтоолтоор хятад сурвалжид МЭӨ 160-126 оны үед тэмдэглэгдсэн *гули* (谷蠡, gǔlǐ)-ийн Баруун Хань улс болон түүний арай өмнөх түүхэн үед холбогдох дуудлагын сэргээлт нь *гули*-г *хүлэг* биш гэж үзэх ноцтой үндэс болж болох юм. Иймээс бид *гули*-ийн Баруун Хань (ЗХ.) болон эртний (ОС.) дуудлагыг үндэслэн тайлбарлах шаардлагатайг ойлгож, туршиж үзэхээр шийдсэн юм.

Баруун Ханьгийн үед *гу-* ба *-ли* үсгийг хэрхэн дуудаж байсныг С.Старостиний судалгаанд тулгуурлаж сэргээв. Гэхдээ түүний цахим тольд яг *ли* (蠡) гэсэн үсгийн сэргээлт байхгүй, харин дундад (МС) үеийн дуудлага ижил сэргээгдэх, одоо цагт бас *li* гэж дуудах өөр үсэг (禮)-ийн сэргээлтээр орлуулж хэрэглэв.

Хүннүгийн үеийн Баруун Хань улсын цагт *гули*-г ЗХ. \*kök-rjǽj (Старостин, 1660: 296) гэж дуудаж байжээ. Харин эртний дуудлага нь ОС. \*qʰok-rʰijʔ (OCR, 2011:43, 78). Энэ хоёр сэргээлтийг үндэслэвэл, МЭӨ 202 - М.Э. 9 оны үед \*kōj, түүнээс өмнөх үед<sup>6</sup> \*qʰogī гэж буюу \*kōj ~ \*qogī дуудаж байжээ гэж таамаглаж болох юм. Төв Азийн нүүдэлчид түүний дотор монгол угсааны *татар*, *хятан*, тунгус угсааны *зүрчидүүд* хэрэглэж байсан «хури/qurī» гэдэг цолтой их төстэй сэргээлт гэж шууд л харагдаж байна.

*Хури* гэсэн үг ямар утгатай, аль хэлний үг болох талаар дорно, өрнийн хэдэн эрдэмтэн саналаа хэлжээ. Тухайлбал, И. де Рахевильц, *хури* юу гэсэн үг болох нь үл мэдэгдэнэ, гэхдээ яах аргагүй маш эртний цол мөн<sup>7</sup> гэсэн бол японы эрдэмтэн Нака Мичиё 1907 оны “Чингис ханы үнэн тэмдэглэл” гэдэг зохиолдоо *хури*-г “хураах” гэсэн утгатай монгол үг гэж тайлбарласныг Пеллио дурдаад, *хури* цолыг монгол угсаатай *хятан* нараас *зүрчидүүд* зээлсэн гэжээ. Пеллиогийн бичсэнээр бол, хятадын эрдэмтэн Ту Жи *хури* цол мөн гэдгийг батлах *хури*

<sup>5</sup> Doerfer G. 1967. *Türkische und Mongolische Elemente im Neupersischen*. Band III. Türkische Elemente im Neupersischen *gim bis kāf*. Wiesbaden, Franz Steiner Verlag GmbH. S. 653-654.

<sup>6</sup> Өөрөөр хэлбэл, МЭӨ VI зууны үе гэсэн үг.

<sup>7</sup> de Rachewiltz I. 2004. *The Secret History of the Mongols*. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. Translated with a Historical and Philological commentary. Vol. I. Brill, Leiden – Boston. pp. 492-493.

(хули, 忽魯, hulu) цолын хятад эквивалент/жишиг нь “зуншуай (commander-in-chief, 總帥, zhongshuai)” гэсэн баримтыг Алтан улсын түүхээс эшилсэн гэнэ<sup>8</sup>.

Бид ч мөн хури (忽里, huli)-ийн ЕМС. хwət-li' < \*qurǰ' сэргээлтэд тулгуурлаж “орчин цагт хураагч гэж хувьсан хөгжсөн эртний монгол үг байх” (Батсүрэн нар, 2019:202 тал зүүлт 72) гэсэн таамаг дэвшүүлсэн билээ. Харин тус цол нь бүр эрт үеийн хүннүүдэд байж болох юм гэж тэр үед огт гадарлаагүй байсан.

Хүннүгийн гули бол хожуу үеийн хятад сурвалжийн гэрчилж буйгаар хятан, татар, зурчид зэрэг Төв Азийн нүүдэлчдэд хадгалагдаж үлдсэн хури цол юм гэдэг санал өмнөх гули бол хүлэг гэсэн таамгаас илүү үнэнд дөхсөн санал гэж бид үзэж байна. Хамгийн гол нь гули-ийн сэргээлт ингэж үзэх үндэслэл болж байгаа юм. Мөн хятан, татар, зурчидийн хэрэглэж ирсэн байдал, Тэмүжинд уул цолыг өөр үгтэй хамтатгаж өгсөн түүхэн жишээг үзвэл гули бол хури юм гэсэн саналд боломж өмнөх тайлбаруудыг бодвол хамаагүй их юм шиг.

Бас тэмдэглэн өгүүлэхэд гу гэсэн үсгийг лу болгож унших нь гажуудал биш ажээ. Го Шилян, Э.Пуллиблэнк нарын дундад эртний дуудлагын сэргээлтээр гу нь лу байж болох аж. Лу гэсэн хувилбарын эртний дуудлага нь Жэнжан Шанфан (zhengzhang shangfang)-ы сэргээх системд гу-аас бараг л ялгарах зүйлгүй сэргээгдэж байна. Өөрөөр хэлбэл, гу-ийн ОС. \*g·goog/\*kloog бол лу-гийнх \*log < \*g·loog (2003:337) гэж байна.

Гули цолыг орос, хятадын эрдэмтэд хориг, харгу, хүрээ гэсэн түрэг, монгол үг гэж үзсэн нь хүлээн зөвшөөрч боломгүй саналууд болжээ. Бид гули бол монгол хэлний хүлэг (үлэмж том гэсэн утгаар), эсвэл хури (хураах, хураагч гэсэн утгатай) гэсэн үг байж болох юм гэсэн хоёр хувилбар дэвшүүллээ, гэхдээ гули бол хури гэсэн эртний монгол үг байх боломж хүлэг-ийг бодвол хавьгүй их юм шиг санагдана.

Данху ван. Хүннүгийн ноёд зүүдэг цолуудаас хамгийн төвөгтэй, өнөөг хүртэл тайлбарлаж чадаагүй цолын нэг нь данху (當戶, danghu) билээ.

Хүннүгийн түүхийн баримт мэдээг түүвэрлэж орчуулсан де Гро данху болон гудухоу цолыг хятад орчуулга биш, үл тайлбарлагдана хэмээгээд овог, аймгийн нэр байх магадлалтай гэсэн<sup>9</sup>.

Б.Карлгрений толиор бол данху-г АгС. \*tāng-g'о гэж сэргээнэ. Г.Сүхбаатар энэ сэргээлтэнд тулгуурлаж “данху” гэдэг тушаалын нэрийн нэхэн сэргээлтийг үзвэл “дарга” гэсэн үг байж болмоор байна” (1972:202) гэж үзсэн билээ.

Туци (t'u-ch'i), гули (ku-li), гуду (ku-tu) болон данху (tang-hu) гэсэн 4 цол хүннү хэлний язгуур үгс гэсэн Н.Ямада хүннүгийн данху бол яах аргагүй цэргийн цол болно гэжээ<sup>10</sup>.

Гэвч данху-г хятад үг гэж тайлбарласан зүйл бий. Дан-г “үйлчлэх” гэх мэт, харин ху-г ажил мэргэжлийн нэр заасан үгийн дагавар (өөрөөр хэлбэл, монгол хэлний -чин лугаа адил) гэсэн Б.Карлгрений тайлбарыг А.Дыбо дурдаад “албан хаагч” гэх хятад үг биш биз (2007:81) гэжээ.

Данху бол хүннү үгийн галиг, харгуулж хятад үгээр жишсэн нэр биш гэсэн Э.Гил данху цолтой түшмэл эсвэл язгууртныг цэргийн зөвлөх, элчээр төрийн хэрэгт зарж байсан гэж “Түүхийн тэмдэглэл”-ийн 110. 2901-2, «Хань улсын бичиг»-ийн 54. 2453-т тэмдэглэсэн мэдээг үндэслэж өгүүлэхдээ зөвхөн данху нар л ийм үүрэг гүйцэтгэж байсан гэдэгт хатуу итгэж болохгүй шүү (2010:261) гэжээ.

Данху бол хүннү үгийн галиг гэсэн де Гро, Н.Ямада, Э.Гил нарын санал зөв байх.

Мөн хоёр ч судлаачийн данху бол цэргийн талдаа цол гэсэн нь ч үндэстэй болов уу. Харин ямар хүннү үг болохыг олж тогтооход дуудлагын сэргээлт гол үндэс болох нь ойлгомжтой. Б.Карлгрений судалгаанаас хойш гарсан хятадач нарын судалгааг үндэслэвэл данху-ийн

<sup>8</sup> Pelliot P. 1959. Notes on Marco Polo. I. Paris, Imprimerie Nationale, Librairie Adrien Maisonneuve. pp. 293-294.

<sup>9</sup> Die Hunnen, S. 56

<sup>10</sup> Yamada N. 2008. Formation of the Hsiung-nu Nomadic State – АОН. Том. XXXVI, Fasc. 1-3. 1982, p. 576; Ямада Н. Образование кочевника Хунну – Монгольская империя и кочевой мир. Книга 3. Ответ. ред. Б.В.Базарова, Н.Н.Крадин, Т.Д.Скрынникова. Улан-Удэ. Изд-во БНЦ СО РАН. стр. 272, 273.

эртний дуудлага нь ОС. \*taŋ-γu (Го Шилян, 1986); ЗХ. \*tāŋ-gá ~ \*tāŋ-γá (Старостин, 1996); ЛН. \*taŋ-qa, ОСМ. \*tāŋ-gâ? (Шюсслер, 2009); ОС. \*tʰaŋ-m-qʰa (Бакстер-Сагар, 2011) гэж байна<sup>11</sup>. Эдгээрээс Бакстер-Сагарын \*tʰaŋ-m-qʰa анхаарал татах ба бага зэрэг хувиргавал \***taŋm·qa** ~ \***tamm·qa** байж болох юм.

“Монголын нууц товчоон”-д Өгэдэй хаан “төдүй Алтан ханыг мухутгаж, сэ’үсэ нэр өгч, алтан мөнгөн алтат харту (эд) агуурс таваар, алашас (агт морьд) сэ’үсэс (албат зарц)-ийг нь дагуулж, **алгинч, таммачин** талбиж, Намгин, Жүндү зүг зүгийн балгасанд даругачин талбиж түвшин түгэл харьж Хархорумаа буув” гэсэн мэдээ байдаг. Мөн “Чормахан хорчи Багдад иргэнийг элсүүлжүхүй. Тэр газар сайн эд сайн гэгдэмүй гэж мэдэж Өгэдэй хахан зарлиг болруун: «Чормахан хорчийг мөн тэнд **тамма** сууж [эд барааг он] онд хүргүүлж илээн-атхун гэв»” хэмээн зарлиг буулгасан мэдээ бий<sup>12</sup>. Дурдсан хоёр мэдээнд гарч буй *таммачин* бол зарлиг хүлээж сууж буй этгээдийг харин *тамма* гэдэг нь томилгоог нь хэлж байх шиг.

“Монголын нууц товчоон”-ы Өгэдэй хааны бүлэг (са. 1240)-ийн *тамма* (SHM. tamma), *таммачин* (SHM. tammacin) нь Хүннүгийн *данху* цолын уламжлал ба чухам \***taŋm·qa** ~ \***tamm·qa** гэх хувилбар \***tamaqa**-ийн галиг аж.

Зарим эрдэмтний судалгаанаас үзэхэд лав Зүүн Ханьгийн үед санскрит зэрэг харь хэлний *-m* -ийг *ханьгийхан -ng/ŋ* -ээр галиглаж байжээ (Coblin South, 1983:89). Үүгээр бол \***tāŋ-γá** гэх сэргээлтээс ч гэсэн \***tāmγá** ~ **tamaqa** гэх язгуур тэнхрүүлэх бололцоотой юм.

*Тамма/таммачин*-ий тухай эрдэмтэд янз бүрийн санал хэлжээ. Игор де Рахевильц, *таммачи*-г “хүрээ цэрэг” (Garrison troops) гээд бүр Монголын эрний өмнөх үед холбогдох чухал институтын нэршил, *тамма* гэдэг язгуурт *-чи* дагавар залгана гэж 2004 онд бичсэн. Гэхдээ, *тамма*-ийн гарлыг монголын *алгинч* гэдэгтэй ойр утгатай хятадын *таньма* (探馬, scout horse)-аас үүсэлтэй гэж ойлгогдохоор тайлбарлажээ<sup>13</sup>. Гэтэл тус үгийг бүр *тамгач* болгож бичих тохиолдол бас бий<sup>14</sup>.

*Тамма/таммачин* гэдэг үгийг шинжилсэн ажлуудаас цэргийн түүхч Ж.Базарсүрэнгийн судалгааг онцолж байна. Тэрээр *тамма* бол монгол хэлний “тамах” хэмээх үгтэй нэг язгууртай, нэг төрлийн тусгай баг цэргийн нэр томьёо, *таммачин* гэдэг нь *тамма* цэргийн ноёныг бусдаас ялгаж нэрлэсэн нэр гэж тайлбарласан билээ<sup>15</sup>.

Түүний саналыг Н.Ямада, Э.Гил нарын *-данху* (\***taŋma/tamma**) бол цэргийн цол мөн эсвэл *данху* цолтой түшмэдийг цэргийн зөвлөхөөр хэрэглэж байсан гэх мэдээ, судалгааг харьцуулж үзвэл хүннүгийн *данху*-г хожуу үеийн монголын *тамма* гэж үзэх нэг үндэс болж болох л юм.

### Abstract

In this article about Ku-li (谷蠡, guli) and Tang-hu (當戶, danghu), the titles of Hsiung-nu princes, the author concludes that these words could be the ancient form of *ja’ut-quri* and *tamma-cin*, recorded in various histories from the X<sup>th</sup> to the XIII<sup>th</sup> centuries.

<sup>11</sup> Го Шилян, т. 252, 94; Китайские иероглифы. Составитель С.А.Старостин (цахим PDF толь), стр. 1151, 66; Schuessler A. Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensa. UHP., Honolulu. 3-32, 1-6; Baxter, W. and L.Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011. pp. 24, 51.

<sup>12</sup> Index to the Secret History of the Mongols by Igor de Rachewiltz. Indiana University, Bloomington, 1972, §§ 273, 274, 276, 281.

<sup>13</sup> de Rachewiltz I. 2004. The Secret History of the Mongols. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. Translated with a Historical and Philological commentary. Vol. II. Brill, Leiden - Boston. pp. 102-1003

<sup>14</sup> Монголын нууц товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар хийсэн Д.Цэрэнсодном. Уб., Мөнхийн үсэг, 2000, §§ 273, 274, 276, 281; Монголын нууц товчоо. Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., Соёмбо принтинг, 2006, §§ 273, 274, 276, 281.

<sup>15</sup> Базарсүрэн Ж. 2013. “Таммачин” уу, “тамгачин” уу? – НМ. Том. XII. МУИС. НШУС. ЭШБ, №34 (396). Уб., т. 23-31.

Номзүй

- De Groot J.J.M.** 1921. *Die Hunnen der Vorchristlichen Zeit Chinesische urkunden zur Geschichte Asiens*. Erster teil. Übersetzt und Erläutert. Berlin und Leipzig, VVW., Walter de Gruyter.
- Giele, Enno.** 2010. The Hsiung-nu. Memoirs 50 – *The Grand Scribe's Records*. Volume IX. The Memoirs of Han China, Part II by Ssu-ma Ch'ien. Edited by William H.Nienhauser, Jr. IUP., Bloomington & Indianapolis. pp. 237-310.
- Index to the Secret History of the Mongols by Igor de Rachewiltz.* 1972. Indiana University. Bloomington.
- Монголын нууц товчоо.* 2000. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар хийсэн Д.Цэрэнсодном. Улаанбаатар. Мөнхийн үсэг.
- Монголын нууц товчоо.* 2006. Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. Улаанбаатар. Соёмбо принтинг.
- de Rachewiltz I.** 2004. *The Secret History of the Mongols*. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. Translated with a Historical and Philological commentary. Vol. I. Brill, Leiden - Boston.
- de Rachewiltz I.** 2004. *The Secret History of the Mongols*. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. Translated with a Historical and Philological commentary. Vol. II. Brill, Leiden - Boston.
- Doerfer G.** 1967. *Türkische und Mongolische Elemente im Neupersischen*. Band III. Türkische Elemente im Neupersischen *ġim bis kāf*. Wiesbaden, Franz Steiner Verlag GmbH.
- Pelliot P.** 1959. *Notes on Marco Polo*. I. Paris, Imprimerie Nationale, Librairie Adrien Maisonneuve.
- Pritsak O.** 1981. Die 24 Ta-ch'ên. Studie zur Geschichte des Verwaltungsaufbaus der Hsiung-nu-Reiche - Studies in Medieval Eurasian History. Variorum Reprints. London. S. 178-202.
- Yamada N.** 1982. *Formation of the Hsiung-nu Nomadic State*. АОН. Tom. XXXVI, Fasc. 1-3. p. 575-582.
- Базарсүрэн Ж.** 2013. “Таммачин” уу, “тамгачин” уу? - НМ. Том. XII. МУИС. ШУС. ЭШБ, №34 (396). Улаанбаатар. х. 23-31.
- Батсүрэн Б., Дэлгэржаргал П., Эрдэнэбат У.** 2019. *Монголын эзэнт гүрний түүх*. Тэргүүн боть. Их Монгол улс. Степпе паблишинг, Улаанбаатар.
- Дэлгэржаргал П., Батсайхан З.** 2017. *Монголын эртний түүх-I боть*: Хүннү. Улаанбаатар. Соёмбо принтинг.
- Сүхбаатар Г.** 1980. Монголчуудын эртний өвөг. Улаанбаатар. ШУАХ.
- Учралт.** 2015. *Хүннү хэлний судлал*. Монгол бичгээс буулгасан М.Жавзансүрэн. Хянан тохиолдуулсан Д.Эрдэнэбаатар. Хятад ханзыг буулгаж хянасан Ба.Батжаргал, Р.Уяа. Улаанбаатар. “Жиком пресс” ХХК.
- Дыбо А.В.** 2007. *Лингвистические контакты ранних тюрков*. Лексический фонд. Пратюркский период. Москва.
- Ямада Н.** 2008. Образование номадного государства Хунну - *Монгольская империя и кочевой мир*. Книга 3. Ответ. ред. Б.В.Базарова, Н.Н.Крадин, Т.Д.Скрынникова. Улан-Удэ, Изд-во БНЦ СО РАН, стр. 271-280.
- Китайские иероглифы*. Составитель С.А.Старостин (цахим PDF толь).
- Baxter W., and L.Sagart.** 2011. *Baxter-Sagart Old Chinese reconstruction* (Version 1.00).
- Coblin, South W.** 1983. *A Handbook of Eastern Han Sound Glosses*. CUP. Hongkong.
- Karlgren B.** 1972 (1957). *Grammata Serica Recensa*. Repinted, Museum of Far Eastern Antiquities. Stockholm.
- Schuessler A.** 2009. *Minimal Old Chinese and Later Han Chinese*. A Companion to Grammata Serica Regensa. UHP. Honolulu.
- 郑张尚芳。2003. 上古音系。上海教育出版社。
- 郭錫良。1986. 漢字古音手冊。北京大学出版社。